



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

Стратеги батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1 дэх заалтыг үндэслэн эрэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” стратегийг нэгдүгээр, “Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Олон улсын байгууллага, хандивлагчдын зээл тусламжаас зохицуулах, дотоодын эх үүсвэрээс гаргах замаар жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я. Буянжаргал/, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Үндэсний лавлагаа төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дарга, захирал нарт даалгасугай.

3. Стратегийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я. Буянжаргал/, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Ө.Ганчимэг/, Үндэсний лавлагаа төвийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Холбогдох хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, байршуулах, тогтвортой ажиллуулах арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т даалгасугай.

5. Стратегийг орон нутагт хэрэгжүүлэх жил бүрийн ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, тайланг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт оны 07 дугаар сарын 25, 01 дүгээр сарын 25-ны дотор ирүүлж байхыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Үндэсний лавлагаа төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А. Эрдэнэтуяа/-д үүрэг болгосугай.



САЙД

Н.УДВАЛ

D:\barimt\tushaal
080268

Эрүүл мэндийн сайдын
2014 оны 03 сарын 17 өдрийн
84 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

“ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНД” СТРАТЕГИ 2014-2018

Нэг. Удиртгал

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого нь хүн ам, хөгжлийн уялдаа холбоог хангахад тохиолдож буй бэрхшээлийг арилгах, хүн төвтэй хөгжилд хүрэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, хүн амын бүлгүүдийн асуудлыг гэр бүлийн хүрээнд шийдвэрлэх, нийгмийн бүхий л харилцаанд жендерийн эрх тэгш байдлыг эрхэмлэхийг эн тэргүүнд чухалчилж байгаа билээ.

2011 онд Монгол Улсын Их Хурлаас “Эрүүл мэндийн тухай хууль”, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиудийг баталж “Хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлнэ”, “Төрөөс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээ бий болгоход чиглэсэн арга хэмжээ авна” хэмээн тус тус хуульчилсан.

2013 онд Монгол Улсын Засгийн газраас баталсан “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах дунд хугацааны стратеги”-т “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн үйлчилгээг хөгжүүлж, хүний нөөцийг бэлтгэх” асуудлыг Эрүүл мэндийн салбар хэрэгжүүлэхээр тусгажээ.

Монгол улсад эрэгтэйчүүдийн дундаж наслалт нь 64.91 бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалтаас (74.3) даруй 9.4 жилээр богино гэсэн тооцоо гарчээ. Ийм ялгаа аль ч улс оронд байдаг хэдий ч манай улсын хувьд дэлхийн дундаж түвшнээс 2.5 дахин их төдийгүй дэлхийн 187 орноос 15-49 насны 1000 эрэгтэйд ногдох сүүлийн 40 жилийн нас баралтын байдлаар 450-иас дээш үзүүлэлттэй 19 орны нэг байгаа нь эрчүүдийн эрүүл мэндийг онцгойлон анхаарах шаардлагатайг харуулж байна.

ДЭМБ-с эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар тусгайлсан стратеги боловсруулж, нийгэм, эдийн засаг, улс төрийн хүчин зүйлийг харгалзах, эрүүл мэндийн тэгш байдлыг дэмжих, эрэгтэйчүүдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, эрүүл чийрэг эр хүн болж төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх, эрэгтэйчүүдийн дундах ялгаварлан гадуурхах байдлыг бууруулах, эрэгтэйчүүд, хөвгүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгосон.

Үүний дагуу эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээг бодлогын түвшинд тусгайлан авч үзэж хөтөлбөр, стратеги, удирдамж боловсруулан хэрэгжүүлж буй улс орнууд цөөнгүй байна. Тухайлбал Европын холбооны улсууд эрчүүд, хөвгүүдийн эрүүл мэндийн талаарх Венийн тунхаглалыг 2005 онд баталсан бол эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн дундаж насны ялгаа өндөртэй Ирланд, Англи, Австрали, Канад, Норвеги, АНУ, Шотланд, Швейцарь зэрэг 11 оронд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар баримтлах бие даасан бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлж байгаа ажээ.

Хоёр. Монгол улсын эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд

2.1 Эрэгтэйчүүдийн нас баралт өндөр байна.

Монгол Улсад жилд дунджаар 17 мянга гаруй хүн нас барж байгаагийн 62 хувь нь эрэгтэйчүүд бөгөөд шалтгаанаар авч үзвэл зүрх судасны тогтолцооны өвчин (33%), осол гэмтэл, гадны шалтгаан (24.9%), хавдар (19.4%) зонхилж байна. Эрэгтэйчүүдийн зүрхний шигдээсийн шалтгаант нас баралт 3.1, даралт ихсэх өвчний шалтгаант нас баралт 2.3, тархинд цус харвалтын нас баралт 1.7, осол гэмтлийн шалтгаант нас баралт 3, амиа хорлолт 7 дахин их байна. Эрэгтэйчүүд элэг, уушигны хорт хавдраар нас барах нь эмэгтэйчүүдээс 8.2- 11.3 хувиар илүү байна.

2.2 Архи, тамхины хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, буруу хооллолт зэрэг амьдралын буруу хэв маяг, дадал зуршил эрэгтэйчүүдэд илүү байгаагаас халдварт бус өвчинд өртөмтгий байна.

15-64 насны эрэгтэй хоёр хүний нэг нь тамхи татаж 37.5 хувь нь архи, согтууруулах ундаа хэрэглэж байна. Хүн амын хоол тэжээлийн үндэсний 4-р судалгаанаас нийт эрэгтэйчүүдийн 40 хувьд нь биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ их хэмээн тодорхойлогдсон ба биеийн жингийн индексийг тооцож үзэхэд гурван эрэгтэйн нэг нь жингийн илүүдэлтэй эсвэл тураалтай байна гэсэн дүн гарчээ.

Архи тамхины хэрэглээ нь эрэгтэйчүүдэд халдварт бус өвчнийг үүсгэж цагаас эрт нас барах, хөдөлмөрийн чадвараа алдах, эдийн засгийн хохиролд оруулдаг гол шалтгаан юм.

2.3 Эрэгтэйчүүдийн дунд эрүүл мэндийн мэдлэг хомс, тусламж эрэлхийлэх хандлага сул байна.

Хүн амын дунд эрэгтэйчүүд эмнэлэгт ханддаггүй, эрүүл мэндийн мэдлэг эмэгтэйчүүдтэй харьцуулахад дорой байдаг гэсэн ойлголт нийтлэг байдаг хэдий ч өвчлөх магадлал нь хүйсийн ялгаанаас хамаарахгүй эмгэгүүдийн хувьд эрэгтэй эмэгтэйчүүдийн үзүүлсэн болон хэвтэн эмчлүүлсэн тоо ойролцоо (0.9-1.1) болохыг эрүүл мэндийн албан ёсны статистик мэдээлэл харуулж байна. Иймд эрэгтэй, эмэгтэйчүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд хандах байдал, түүнд нөлөөлөх олон талт хүчин зүйлийн нөлөөг нарийвчлан судлах шаардлагатай.

2.4. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц эрэлт хэрэгцээг хангасан нарийн мэргэжлийн тасаг, кабинет, мэргэжлийн эмчийн хангамж хувийн хэвшлийн ганц нэг эмнэлгийг эс тооцвол нэн хангалтгүй байна.

Эрэгтэйчүүдийн амьдралын эгзэгтэй мөчүүдэд тулгардаг эрүүл мэндийн асуудлаар зөвлөгөө өгөх, тохирсон тусламж, үйлчилгээ үзүүлэх бүтэц тогтолцоо бүрдээгүй гэхэд болно. Эх хүүхдийн эрүүл мэндийн төвийн Хүүхдийн зөвлөх поликлиникээр үйлчлүүлсэн 0-16 насны хүүхдийн судалгаагаар өсвөр үеийн кабинетэд үзүүлсэн хүүхдүүдийн дөнгөж 2.3 хувь нь хөвгүүд байсан бол бусад тасаг кабинетаар үйлчлүүлэгчдийн дунд хөвгүүдийн эзлэх хувь дунджаар 58.8 хувь байжээ. Энэ нь өсвөр насны хөвгүүдийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн ээлтэй тусламж, үйлчилгээ хараахан бий болоогүйтэй холбоотой.

Үргүйдлийн шалтгааны 43% нь эрчүүдээс хамааралтай нь судалгаагаар тогтоогдсон боловч хүн амын дунд зөвхөн эмэгтэйчүүдтэй холбон ойлгох хандлага нийтлэг тул үргүйдлийн шалтгаанаар анх эмнэлэгт хандаж байгаа нь дан эмэгтэйчүүд байдаг. Энэ нь эрэгтэйчүүдэд хандсан нөхөн үржихүйн зөвлөх үйлчилгээ дутмаг байгааг илэрхийлж байна.

2013 оны эцсийн байдлаар ХДХВ/ДОХ-ын нийт 150 тохиолдол бүртгэгдсэнээс 80.7% (121/150) нь эрэгтэйчүүд тухайлбал 81.8% (99/121)-ийг бэлгийн цөөнх эрчүүд эзэлж байгаа нь эрчүүд тэр дундаа бэлгийн цөөнх эрчүүдийн дунд БЗДХ, ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, өргөжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллага нь Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Урологийн тасаг, төрөлжсөн болон тусгай мэргэжлийн төвүүдийн урологийн кабинет, хувийн цөөн тооны эмнэлэг төдийхнөөр хязгаарлагдаж байна. Гэтэл эрэгтэйчүүдэд өвөрмөцөөр тохиолддог эмгэгүүд нэмэгдэх хандлагатай болжээ. Тухайлбал түрүү булчирхайн үрэвсэлт өвчин 2012 онд 10000 эрэгтэй тутамд 5,7 бүртгэгдсэн нь 2010 оны түвшнээс даруй 36.8 хувиар нэмэгдсэн байна.

2.5. Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаарх нарийвчилсан судалгаа, мэдээлэл хангалтгүй байна.

Хүн амын өвчлөл, нас баралтын байдлыг эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг шаталсан судалгааны үр дүнгээс харж байгаа хэдий ч эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй нийгэм, эдийн засгийн хүчин зүйлстэй холбон гүнзгийрүүлэн судалсан байдал хангалтгүй байна. Түүнчлэн хүн амын эрүүл мэндийн байдлыг илтгэх үндсэн үзүүлэлтүүд болох дундаж наслалт, нас баралтын түвшний хүйсийн ялгаатай байдалд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг Монгол улсын нөхцөл байдалтай уялдуулан нарийвчлан судалсан судалгаа, нотолгоо одоогийн байдлаар хомс байна.

Иймд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн нас баралтын түвшин болон эрүүл мэндийн үзүүлэлт зөрүүтэй байгаа манай улсын хувьд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар бодлого боловсруулах зайлшгүй шаардлагатай хэмээн үзэж энэхүү стратегийг боловсруулав.

Гурав. Стратегийн зорилго, зорилт

Зорилго


Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжиж, тэдэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх замаар эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдлыг сайжруулах

Зорилт

1. Бүх шатны бодлого боловсруулагчид, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид, байгууллага хамт олон, гэр бүл болон эрэгтэйчүүдэд өөрсдөд нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлын чухлыг сурталчлах, ойлгуулах;
2. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн, гэр бүл, хамт олонд тулгуурласан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх;
3. Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх;
4. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээрх судалгаа шинжилгээг өргөжүүлэх замаар бодлогын нотолгоо бий болгох

Дөрөв. Стратегийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

- Жендерийн эрх тэгш байдлыг хангасан байна.
- Олон улс, үндэсний болон салбарын бодлого, хөтөлбөр, стратегитэй уялдсан байна.
- Гэр бүл, хамт олны оролцоонд тулгуурласан байна.
- Салбар хоорондын хамтын ажиллагааг чухалчилсан байна.
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжсэн байна.



Тав. Стратегийн зорилтыг хангах үйл ажиллагааны чиглэл

Зорилт 1.

Бүх шатны бодлого боловсруулагчид, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид, байгууллага хамт олон, гэр бүл болон эрэгтэйчүүдэд өөрсдөд нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлын чухлыг сурталчлах, ойлгуулах;

Хүрэх үр дүн

Нийгмийн бүх давхаргад эрэгтэйчүүд, хөвгүүдийн эрүүл мэндийг дэмжих мэдлэг ойлголт нэмэгдэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- Бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, түүнд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар нөлөөллийн үйл ажиллагаа;
- Эрэгтэйчүүд, гэр бүл, хамт олон, нийгэмд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан болон өвөрмөц асуудлыг таниулж, оролцоог нэмэгдүүлэх;
- Тусламж, үйлчилгээ үзүүлэгчид болон ирээдүйн эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээг ойлгуулахад чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах, тусламж үйлчилгээний талаарх лавлагаа мэдээлэл хүргэх боломжийг бүрдүүлэх.

Зорилт 2.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн, гэр бүл, хамт олонд тулгуурласан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх;

Хүрэх үр дүн

Эрэгтэйчүүд, хөвгүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх бүтэц бий болж тэдэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- Эрэгтэйчүүд хөвгүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцыг тусламж үйлчилгээний шатлал бүрээр тодорхойлох;
- Эрүүл мэндийн хоёрдах шатлалын байгууллагад эрэгтэйчүүд, хөвгүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүтцийг одоогийн тогтолцоонд түшиглэн байгуулах, түүнд шаардлагатай нөөцийг бүрдүүлэх;
- Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн ээлтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах;
- Эрэгтэйчүүдийн амьдралын эгзэгтэй мөчүүдэд (0-5 нас, сургуульд орох нас, бэлгийн бойжилт, өсвөр нас, сургууль төгсөх үе, цэргийн нас, насанд хүрэх үе, гэрлэлт, эцэг, өвөө болох, ажилгүй болох, тэтгэвэрт гарах, салалт, бэлэвсрэлт) тулгарах сэтгэлзүй, эрүүл мэндийн асуудлуудад зөвлөгөө өгөх бүтцийг төрийн

болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэн хөгжүүлэх.

Зорилт 3.

Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх;

Хүрэх үр дүн

Эрэгтэйчүүд, хөвгүүдийн дундах эрсдэлт зан үйл буурч, эрүүл зан үйл төлөвших нөхцөл бүрдэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлтэй зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн мэдээлэл харилцаа, нийгмийн зах зээл, ухуулга нөлөөллийн үйл ажиллагааг эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлж буй бусад бодлого хөтөлбөртэй уялдуулах;
- Нийгмийн бусад салбар, байгууллага, хамт олон, гэр бүлд жендерийн эрх тэгш байдлыг хангасан эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлэх;
- Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл сургалт сурталчилгааг оновчтой арга хэлбэрээр, тасралтгүй зохион байгуулах;
- Цэргийн насны эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааг хүчний байгууллага, сургуультай хамтран хэрэгжүүлэх

Зорилт 4.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээрх судалгаа шинжилгээг өргөжүүлэх замаар бодлогын нотолгоо бий болгох

Хүрэх үр дүн

Эрэгтэйчүүд, хөвгүүдийн зан үйлийн өөрчлөлт, тэдний дундах эрсдэлт хүчин зүйлийн тархалт, өвчлөл нас баралтын байдал, тэдгээрийн шалтгаан нөхцөлийн талаар нотолгоонд тулгуурласан бодлого, шийдвэр гарсан байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдлын дүн шинжилгээт мэдээллээр хэрэглэгчдийг хангах нөхцлийг бүрдүүлэх
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц асуудлаар судалгаа хийх
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлаарх судалгааны чадавхийг дэмжих.

Зургаа. Стратегийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

6.1 Стратегийн хэрэгжилтийн зохион байгуулалт

Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд стратеги нь 2014-2018 онд хэрэгжинэ. Эрүүл мэндийн яам стратегийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв стратегийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг үндэсний түвшинд толгойлж ажиллах бөгөөд эрүүл мэндийн үндэсний лавлагаа төвүүд хамтран ажиллана.

Орон нутгийн түвшинд стратегийг хэрэгжүүлэх чиг үүргийг аймаг, нийслэлийн засаг дарга аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар хамтран хариуцна.

6.2 Хэрэгжүүлэх хугацаа: Стратегийг 2014 -2018 онд хэрэгжүүлнэ.

6.3 Санхүүжилт

- Улсын болон орон нутгийн төсөв
- Эрүүл мэндийг дэмжих сан
- Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр
- Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр

Долоо. Стратегийн хэрэгжилтийн хяналт- шинжилгээ, үнэлгээ, шалгуур үзүүлэлтүүд

7.1 Үндэсний болон орон нутгийн хэмжээнд:

- Стратегийн хэрэгжилтийн хяналт- шинжилгээ, үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу хийнэ.
- Стратегийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг холбогдох байгууллагын оролцоотойгоор явуулна.

7.2 Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2013 оны суурь түвшин	2016 онд хүрэх түвшин	2018 оны зорилтот түвшин
Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаарх зорилтот бүлгүүдийн мэдлэг ойлголтын түвшин	Шинэчлэн тодорхойлох суурь үзүүлэлт	50 хувь	70 хувь
Ухуулга нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан төрийн албаны шийдвэр гаргагчдын хувь	10	20- 30	60-70
Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр сургагдсан сум өрхийн эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтнүүдийн хувь	-	30-40	60-70
Эрэгтэйчүүдийн эмчтэй аймаг, дүүргийн тоо		15	30
Эрэгтэйчүүдийн кабинеттай аймаг, дүүргийн тоо		15	30
Эрэгтэйчүүдийн кабинетээр үйлчлүүлэгчдийн жилийн өсөлтийн хувь	Жил бүр 10-20 хувь		
Цэргийн насны эрэгтэйчүүдийн эрүүлжилтийн хувь	40	50	60

Эрүүл мэндийн сайдын
2014 оны 03 сарын 17-дөдрийн
84 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

“ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНД” СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт 1. Бүх шатны бодлого боловсруулагчид, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид, байгууллага хамт олон, гэр бүл болон эрэгтэйчүүдэд өөрсдөд нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлын чухлыг сурталчлах, ойлгуулах; Хүрэх үр дүн: Нийгмийн бүх давхаргад эрэгтэйчүүд, хөвгүүдийн эрүүл мэндийг дэмжих мэдлэг ойлголт нэмэгдэнэ.											
№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Хугацаа					Шалгуур үзүүлэлт		
				2014	2015	2016	2017	2018			
1.1 Бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад эрэгтэйчүүдийн эрүүл мэнд болон эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар ухуулга нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр											
1.1.1	Хууль тогтоогчид болон бусад салбарын шийдвэр гаргагчдад “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” стратегийг танилцуулах уулзалт зохион байгуулах	ЭМЯ НЭМХ	НЭМҮТ	+				+	Мэдээлэл авсан хууль тогтоогчид, шийдвэр гаргагчдын тоо		
1.1.2	Эрүүл мэндийн сайдтай харилцан ойлголцлын санамж бичиг зурж хамтран ажиллаж буй улс төрийн бүлгийн төлөөллүүдтэй стратегийг танилцуулах ажлын уулзалтуудыг зохион байгуулах	ЭМЯ НЭМХ	НЭМҮТ	+				+	Мэдээлэл авсан улс төрчдийн тоо		
1.1.3	Аймаг, нийслэлийн ИТХ болон Засаг дарга нарт стратегид туссан үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхэд санхүүгийн болон захиргааны дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн нөлөөллийн уулзалт, үйл ажиллагаа зохион байгуулах	Аймаг нийслэлийн ЭМГ ТББ	ЭМЯ НЭМХ НЭМҮТ	+				+	Мэдээлэл авсан ИТХ болон Засаг даргын тоо		

Зорилт 1. Бүх шатны бодлого боловсруулагчид, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид, байгууллага хамт олон, гэр бүл болон эрэгтэйчүүдэд өөрсдөд нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлын чухлыг сурталчлах, ойлгуулах;
Хүрэх үр дүн:
 Нийгмийн бүх давхаргад эрэгтэйчүүд, хөвгүүдийн эрүүл мэндийг дэмжих мэдлэг ойлголт нэмэгдэнэ.

1.1.4	Ухуулга нөлөөллийн үйл ажиллагааг зорилтот бүлэг бүрт тохирсон агуулга, хэлбэр, сувагаар хүргэх, үр дүнг үнэлэх арга хэрэгслийг боловсруулан хэрэгжүүлэх	Нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх туршлагатай ТББ	НЭМҮТ	+	+	+	Ухуулга нөлөөллийн үйл ажиллагааны төлөвлөгөө гарч хэрэгжсэн байна.
1.1.5	Төрийн захиргааны төв байгууллагуудын дэргэдэх Жендерийн салбар хороо болон жендерийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд стратегийг танилцуулах уулзалт зохион байгуулах	ЭМЯ-ны Жендерийн салбар хороо	Жендерийн үндэсний хороо	+			Уулзалтын тайлан
1.2 Эрэгтэйчүүд, гэр бүл, хамт олон, нийгэмд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан болон өвөрмөц асуудлыг таниулж, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр							
1.2.1	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр олон нийтийн мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллах	ЭМЯ ТЗУГ	ОНХМХ	+	+	+	Гэрээ байгуулж, хамтран ажилласан байгууллагын тоо
1.2.2	Эрэгтэйчүүдэд нийтлэг тохиолддог эрүүл мэндийн асуудлуудыг хөндсөн телевиз, радиогийн цуврал нэвтрүүлэг, ярилцлага, хэлэлцүүлгийг зохион байгуулах	ЭМЯ Хэвлэлийн алба НЭМҮТ	ДЭМБ НҮБХАС Харьяа байгууллагууд	+	+	+	ОНХМХ-ээр явуулсан МСС-ны тоо, тайлан
1.2.3	Эрэгтэйчүүд, хөвгүүдэд зориулсан эрүүл мэндийн цахим сайт, булан ажиллуулах, ажиллаж буй цахим сайтуудад эрэгтэйчүүдэд зориулсан булан бий болгох	НЭМҮТ	Сайтууд	+	+	+	Ажиллаж буй цахим сайт булангийн мэдээлэл
1.2.4	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг хэлэлцэх facebook бүлэг ажиллуулах	НЭМҮТ	ТББ	+	+	+	facebook хаяг, мэдээлэл
1.2.5	Эрэгтэйчүүдийн мэдлэгийн түвшин, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор цахим сайт болон facebook бүлгээр хэлэлцэж буй асуудалд дүн шинжилгээ хийх, цаашдын үйл ажиллагаанд ашиглах	НЭМҮТ	ТББ				Жил бүрийн дүн шинжилгээний тайлан

1.2.6	Эрэгтэйчүүд олноор ажилладаг салбар болон байгууллага, кампаниудын удирдлагуудад Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц, асуудал, түүнийг шийдвэрлэхэд хамтран ажиллах талаар нөлөөллийн сургалт, уулзалтууд зохион байгуулах	ЭМЯ НЭМХ ТББ	ДЭМБ НУБХАС УУЯ ЗТЯ БХБЯ ХЗЯ БХЯ	+	+	+	+	+	Хамтран ажиллаж буй байгууллагын тоо, ажиллагааны тайлан
1.2.7	Гэр бүлээсээ хол ажиллаж байгаа залуучуудын эрүүл мэнд, гэр бүлийн амьдралыг дэмжих, хамгаалах чиглэлээр орон нутгийн төрийн захиргааны байгууллага, хөрөнгө оруулагч, төсөл хэрэгжүүлэгч, аж ахуйн нэгж, компанигай хамтран ажиллах	ЭМЯ НЭМХ ТББ	ХАХНХЯ Аймаг, нийслэлийн ЗДТГ Хөрөнгө оруулагч Төсөл хэрэгжүүлэгчид, аж ахуйн нэгж, компаниуд	+	+	+	+	+	Хамтран ажиллаж буй байгууллагын тоо, ажиллагааны тайлан
1.3 Тусламж, үйлчилгээ үзүүлэгчид болон ирээдүйн эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээг ойлгуулахад чиглэсэн сургалт сурталчилгаа зохион байгуулах, тусламж үйлчилгээний талаарх лавлагаа мэдээлэл хүргэх боломжийг бүрдүүлэх чиглэлээр									
1.3.1	Эрүүл мэндийн байгууллагуудад стратегийг танилцуулах семинарыг бүсчилэн зохион байгуулах	ЭМЯ НЭМХ	Аймаг, нийслэлийн ЭМГ	+	+	+	+	+	Уулзалт семинарын тайлан
1.3.2	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээ, шаардлагатай тусламж, үйлчилгээний талаар эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан гарын авлага материал боловсруулж, тохиромжтой бүх сугаар түгээх	НЭМҮТ ЭМШУИС	ЭМЯ-ны харъяа байгууллагууд	+	+	+	+	+	Гарын авлага материалын тоо төрөл
1.3.3	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц асуудлууд, шаардлагатай тусламж үйлчилгээний талаар эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэх төгсөлтийн өмнөх сургалтын хөтөлбөрт тусгах асуудлыг шийдвэрлэх	ЭМЯ ХНХХ	БШУЯ, Эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэх их, дээд сургуулиуд	+	+	+	+	+	Төгсөлтийн өмнөх сургалтын хөтөлбөрт тусгасан асуудал, цаг
1.3.4	Өрх сумын эмч нарт зориулан	ЭМХТ	Өрхийн эмч	+	+	+	+	+	Сургагдсан эмч,

эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц асуудлын талаар болон эрэгтэйчүүдэд нийтлэг тохиолддог эмгэгүүдийг таних, эрт илрүүлэх, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай тохиолдолд дараачийн шатны тусламж үйлчилгээнд шуурхай илгээх мэдлэг, чадвар олгох сургалт зохион байгуулах		нарын нийгэмлэг ЭМХТ			мэргэжилтнүүдийн тоо
1.3.5	Гэр бүлийн урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөөг хоёр жил тутам зохион байгуулж, гэр бүлийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа явуулах	Орон нутгийн төр захиргааны байгууллага ТББ	+	+	Урьдчилан сэргийлэх хамрагдсан гэр бүлийн тоо
Зорилт 2. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн, гэр бүл, хамт олонд тулгуурласан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх;					
Хүрэх үр дүн Эрэгтэйчүүд, хөвгүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх бүтэц бий болж тэдэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.					
2.1 Эрэгтэйчүүд, хөвгүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцыг тусламж үйлчилгээний шатлал бүрээр тодорхойлох					
2.1.1	Эрэгтэйчүүд, хөвгүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдлыг үнэлэх	ЭМЯ ХШУДАГ	+	+	Боловсруулж хэрэгжүүлж буй удирдамж, журам
2.1.2	Үнэлгээний үр дүнд суурилан эрэгтэйчүүд, хөвгүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний удирдамж, гарын авлагыг шатлал тус бүрээр шинэчлэн боловсруулах	ЭМЯ ЭТХ ОЭТХ	+	+	Боловсруулж хэрэгжүүлж буй удирдамж, гарын авлага
2.1.3	Удирдамж гарын авлагыг ашиглах талаар тусламж үйлчилгээ үзүүлэгчдэд сургалт зохион байгуулах	ЭМЯ ЭТХ ОЭТХ			Сургагдсан эмч, мэргэжилтний тоо
2.1.4	Хөвгүүд, эрэгтэйчүүдэд өвөрмөцөөр тохиолддог зарим эмгэгүүдийн илрүүлэг, үзлэгийн удирдамж боловсруулж нэвтрүүлэх	ЭМЯ ЭТХ НЭМХ			

2.1.5	Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгийн дүнд үндэслэн цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Аймаг, нийслэлийн ЭМГ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	+	+	+	Цэрэгт залуусын хувь тэнцэх
2.2	Эрүүл мэндийн хоёрдах шатлалын байгууллагад эрэгтэйчүүд, хөвгүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бүтцийг одоогийн тогтолцоонд түшиглэн байгуулах, түүнд шаардлагатай нөөцийг бүрдүүлэх	ЭМЯ СЭЗХ ОЭТХ	Аймаг, нийслэлийн ЭМГ	+	+	+	Судалгааны тайлан, зөвлөмж
2.2.1	Эрүүл мэндийн хоёрдах шатлалын байгууллагад эрэгтэйчүүд, хөвгүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцыг үзүүлэх кабинет байгуулахад шаардлагатай нөөцийн судалгаа хийх	ЭМЯ СЭЗХ ОЭТХ	Аймаг, нийслэлийн ЭМГ	+	+	+	Судалгааны тайлан, зөвлөмж
2.2.2	Эрэгтэйчүүд, хөвгүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх кабинет байгуулах үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүлж, шаардагдах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгах	ЭМЯ СЭЗХ	Аймаг, нийслэлийн ЭМГ	+	+	+	Авсан хэмжээний үр дүн
2.2.3	Эрэгтэйчүүдийн кабинетуудыг нэн шаардлагатайтай багаж хэрэгсэл, урвалж, эм, оношлуураар хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	ЭМЯ ОЭТХ СЭЗХ	Аймаг, нийслэлийн ЭМГ	+	+	+	Нийлүүлж хангасан багаж, урвалж, оношлуурын тоо, төрөл
2.2.4	Эрэгтэйчүүд, хөвгүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх кабинетэд тавигдах бүтэц үйл ажиллагааны нийтлэг шаардлага боловсруулж, батлуулах	ЭМЯ ОЭТХ	ЭХЭМҮТ Улсын 1 дүгээр төв эмнэлэг	+	+	+	Боловсруулж батлуулсан бүтэц, үйл ажиллагааны шаардлага
2.2.5	Эрэгтэйчүүдийн өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй эмгэгүүдээс сэргийлэх, эмчлэх эм, эмнэлгийн хэрэгслийн үнэлгээ хийж, зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад оруулах	ЭМЯ ЭЭХХ	Аймаг, нийслэлийн ЭМГ	+	+	+	Үнэлгээ хийгдэж эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт гарсан байна.
2.3	Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах						
2.3.1	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн мөрдөх	ЭМЯ ХНХХ БУХХ	Аймаг, нийслэлийн ЭМГ	+	+	+	Судалгааны тайлан Шинэчлэн боловсруулсан ажлын байрны тодорхойлолт

Хүрэх үр дүн : Эрэгтэйчүүд, хөвгүүдийн дундах эрсдэлт зан үйл буурч, эрүүл зан үйл төлөвшинө.									
3.1 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлтэй зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн мэдээлэл харилцаа, нийгмийн зах зээл, ухуулга нөлөөллийн үйл ажиллагааг эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлж буй бусад бодлого хөтөлбөртэй уялдуулах									
3.1.1	Эрэгтэйчүүдийн хэрэгжих нийгмийн хөтөлбөр, бусад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд үнэлгээ хийх	Эрэгтэйчүүдийн стратегитэй уялдан эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр, бусад стратегийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, үйл ажиллагааны төлөвлөгөөнд үнэлгээ хийх	ЭМЯ НЭМХ	НЭМҮТ ЭХЭМҮТ ХСҮТ ГССҮТ СЭМҮТ ХӨСҮТ	+				Үйл ажиллагааны нэгдсэн тайлан
3.1.2	Үнэлгээнд үндэслэн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр, стратегийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг жил бүр батлан, хэрэгжүүлэх	ЭМЯ НЭМХ	НЭМҮТ		+	+	+	+	Жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан
3.2 Нийгмийн бусад салбар, байгууллага, хамт олон, гэр бүлд жендерийн эрх тэгш байдлыг хангасан эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлэх									
3.2.1	Эрүүл мэндийг дэмжих байгууллага шалгаруулах болзол, журмыг шинэчлэн боловсруулах, жендерийн эрх тэгш байдлыг хангах асуудлуудыг тусгах	НЭМҮТ	ДЭМБ		+				Шинэчлэн боловсруулсан журам
3.2.2	Байгууллага, хамт олны дунд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөр шалгаруулж, хэрэгжүүлэх, туршлагыг сурталчлах	НЭМҮТ Аймаг, нийслэлийн ЭМГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ		+	+	+	+	Хэрэгжүүлсэн төслийн тайлан
3.2.3	Эрүүл ажлын байр хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, эрэгтэйчүүд олноор ажилладаг байгууллагын менежерүүдэд ухуулга нөлөөллийн сургалт зохион байгуулах	НЭМҮТ	Эрүүл ажлын байр үндэсний сүлжээ Худалдаа аж үйлдвэрийн танхим		+	+	+	+	Сургалтын тайлан
3.2.4	Ганц бие аавуудын эрүүл мэнд, нийгмийн асуудлыг хөндсөн үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулах	ЭМЯ НЭМХ	Жендерийн үндэсний хороо		+				Хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж, тайлан

3.3 Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрсдлээс сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааг зорилтот бүлэгт оновчтой арга хэлбэрээр, тасралтгүй зохион байгуулах

3.3.1	Хүчний байгууллага, цэргийн анги, бүтээн байгуулалт зэрэг эрэгтэйчүүд давамгайлан ажилладаг салбаруудын ажилтан албан хаагчдад эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгааг тогтмол явуулах арга замыг тодорхойлж холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	НЭМҮТ	Төр хувийн хэвшлийн түншлэлээр	+	+	+	+	Хамтран ажиллаж буй байгууллагын тоо, ажиллагааны тайлан
3.3.2	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, оюутан залуучуудын дунд архи тамхины хэрэглээг бууруулах, идэвхитэй хөдөлгөөн, зохистой хооллолтыг дэмжих, бэлгийн эрсдэлтэй зан үйлээс сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааны шинэлэг, сонирхолтой арга хэлбэрийг шалгаруулах уралдаан зарлах	НЭМҮТ	ТББ	+	+	+	+	Шалгарсан төслийн тоо
3.3.3	Эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлэгчид эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц асуудал, тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг хүртээмжтэй авах нөхцлийг бүрдүүлэх	Харъяа байгууллагууд Аймаг, нийслэлийн ЭМГ	ДЭМБ НУБХАС НУБХС	+	+	+	+	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан
3.3.4	Багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын агуулга хөтөлбөрийг хянан үзэж, шинэчлэн боловсруулах, эрэгтэйчүүд, хөвгүүдийн эрүүл мэндийн асуудлыг оруулах	ЭМЯ НЭМХ НЭМҮТ	БШУЯ НБГ	+	+	+	+	Үнэлгээний тайлан, зөвлөмж Боловсруулсан санал
3.3.5	ЕБС-ийн эрүүл мэнд хичээлийн хөтөлбөрт хөвгүүдийн эрүүл мэндийн өвөрмөц асуудлын талаарх хичээлийн цагийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах	ЭМЯ НЭМХ	БШУЯ НБГ	+	+	+	+	Үйл ажиллагааны тайлан
3.3.6	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих аянг жил бүр зохион байгуулж хэвших	НЭМҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	+	+	+	+	Үйл ажиллагааны тайлан

3.3.7	Зан үйлийг өөрчлөх мэдээлэл сургалт сурталчилгааг эрсдэлт бүлгийн эрэгтэйчүүдийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн арга хэлбэрээр зохион байгуулах	НЭМҮТ ХӨСҮТ	ТББ	+	+	+	+	+	Үйл ажиллагааны тайлан
Зорилт 4. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээрх судалгаа шинжилгээг өргөжүүлэх замаар бодлогын нотолгоо бий болгох									
Хүрэх үр дүн: Эрэгтэйчүүд, хөвгүүдийн зан үйлийн өөрчлөлт, тэдний дундах эрсдэлт хүчин зүйлийн тархалт, өвчлөл нас баралтын байдал, тэдгээрийн шалтгаан нөхцөлийн талаар нотолгоонд тулгуурласан бодлого, шийдвэр гарсан байна.									
4.1 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдлын дүн шинжилгээт мэдээллээр хэрэглэгчдийг хангах нөхцлийг бүрдүүлэх									
4.1.1	Нийгмийн эрүүл мэндийн томоохон судалгаануудын үр дүн, эрүүл мэндийн статистик мэдээллийг түшиглэн эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдлын талаар дүн шинжилгээ хийх чиг үүргийг зохих байгууллагад хариуцуулах	ЭМЯ МХШУДАГ	БХЗГ	+					Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдлын талаар дүн шинжилгээ хийх чиг үүргийг хариуцах нэгж бий болно.
4.1.2	Эрүүл мэндийн статистик мэдээллийн анхан шатны маягт болон тайлангийн маягтуудад дүн шинжилгээ хийж, хүйсээр ялгах шаардлагатай эрүүл мэндийн үзүүлэлтүүдийн жагсаалтыг гаргах	ЭМХТ	НЭМҮТ	+					Хүйсээр ялгах шаардлагатай эрүүл мэндийн үзүүлэлтүүдийн жагсаалт батлагдсан байна.
4.1.3	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн төлөв байдлын талаарх эмхэтгэлийг жилд 1 удаа гаргах	НЭМҮТ	ЭМХТ	+	+	+	+	+	Хэвлэгдэж гарсан эмхэтгэл
4.1.4	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг салбар хооронд харилцан солилцох механизм бий болгох	ЭМЯ НЭМХ	НЭМҮТ ЭМХТ	+	+				Солилцсон мэдээллийн тоо, төрөл
4.2 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц асуудлаар судалгаа хийх									
4.2.1	Эрчүүдийн эрүүл мэндийн асуудлаарх судалгааны ажлын хэрэгцээ, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	Сонгон шалгаруулна							Судалгааны тайлан, зөвлөмж
4.2.2	Дундаж наслалт, нас баралтын түвшний хүйсийн ялгаатай байдалд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судлах	Сонгон шалгаруулна				+			Судалгааны тайлан, зөвлөмж
4.2.3	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж хайх зан үйлийн судалгаа хийх	Сонгон шалгаруулна							Судалгааны тайлан, зөвлөмж

4.2.4	Гадаадад ажиллагсдын эрүүл мэндийн байдалд судалгаа хийх	Сонгон шалгаруулна			+	+	Судалгааны тайлан, зөвлөмж
4.2.5	Уул уурхай, дэд бүтэц зэрэг бүтээн байгуулалтад оролцож буй залуучуудын эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, БЗДХ-ын тархалтын байдалд тогтмол судалгаа хийх	Сонгон шалгаруулна			+	+	Судалгааны тайлан, зөвлөмж
4.3 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлаарх судалгааны чадавхийг дэмжих							
4.3.1	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлаар судалгаа шинжилгээг толгойлон хариуцах баг байгуулах	НЭМҮТ	Анагаах ухааны хүрээлэн	+			Хэрэгжүүлсэн төслийн тайлан
4.3.2	Эрчүүд, хөвгүүдийн эрүүл мэндийн чиглэлээр судлаачдад зориулсан сургалт зохион байгуулах	ЭМШУИС	ТББ		+	+	Сургалтад хамрагдсан судлаачдын тоо
4.3.3	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар жил бүр онол практикийн бага хурал зохион байгуулах	НЭМҮТ	Эрэгтэйчүүдийн ТББ	+	+	+	Зохион байгуулсан онол практикийн бага хурлын эмхэтгэл
4.3.4	Олон улсын эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллах хамтын ажиллагааг өргөжүүлэх	ТББ	НЭМҮТ ЭМХТ	+	+	+	Хамтын ажиллагааны тайлан